



Японы Олон Улсын Хамтын  
Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)  
Монгол дахь Төлөөлөгчийн газар

# ТАНИЛЦУУЛГА

<https://www.jica.go.jp/mongolia/mon/index.html>

## ЖАЙКА

ЖАЙКА нь Япон Улсын Засгийн газрын Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-ийн хоёр талт хамтын ажиллагааг голчлон хэрэгжүүлдэг хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага бөгөөд техникийн хамтын ажиллагаа, иенийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж зэрэг өргөн хүрээтэй хамтын ажиллагааг дэлхийн 150 гаруй улс орон, бүс нутагт явуулж байна.



## МОНГОЛ УЛС ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Япон Улсаас Монгол Улсад чиглэсэн эдийн засгийн хамтын ажиллагаа нь 1977 онд буцалтгүй тусламжаар Говь комбинатыг барьж байгуулснаар суурь нь тавигдаж, Монгол Улс 1990 онд ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа бүрэн утгаараа хэрэгжиж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэлх техникийн хамтын ажиллагаа (ТХА), иенийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн нийт дүн 328.4 тэрбум иенд<sup>(※1)</sup> хүрээд байна. Мөн 1992 оноос хойш 710 гаруй сайн дурын гишүүнийг Монголд томилж, Монголоос 5,200<sup>(※2)</sup> гаруй төрийн албан хаагчийг Япон Улсад сургалтанд хамруулах зэргээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийн дэд бүтцийг бэхжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэхэд хамтын ажиллагаагаа өргөжүүлж ирсэн. Япон Улс нь өнөөг хүртэл тогтмол Монгол Улсын тэргүүлэгч хандивлагч орон байсаар ирсэн бөгөөд энэхүү хамтын ажиллагаанд ЖАЙКА нь гол үүргийг гүйцэтгэж байна.

※1 2020 оны 3-р сарын байдлаар

※2 2021 оны 3-р сарын байдлаар

(Нэгж: сая иен)

	2016	2017	2018	2019	2020
Техникийн хамтын ажиллагаа	2,511	2,358	2,259	2,227	1,293
Иенийн хөнгөлөлттэй зээл (*1)	6,570	32,000	0	0	25,000
Буцалтгүй тусламж (*2)	4,413	3,815	830	1,352	869
<b>Нийт дүн</b>	<b>13,494</b>	<b>38,173</b>	<b>3,089</b>	<b>3,579</b>	<b>27,162</b>

\*1 Иенийн хөнгөлөлттэй зээл, Хувийн хэвшлийн ХО-ын дүнгээр нэгтгэв.

\*2 Жил бүрийн буцалтгүй тусламжийн дүн

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГОЛ ХЭЛБЭРҮҮД

### ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА (ТХА)



ТХА нь Япон Улсын технологи, мэдлэг, туршлагад тулгуурлан хөгжлийн гол түлхүүр болсон хүний нөөцийг хөгжүүлэх, шинэ тогтолцоо бий болгохыг дэмжих зорилгоор Японоос мэргэжилтэн илгээх, Япон улсад сургалтанд хамруулах, техникийн хамтын ажиллагааны төслүүд хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийн шинжлэх ухаан, технологи судалгааны түншлэл (SATREPS) зэрэг хамтын ажиллагаануудын хэлбэрээр хэрэгждэг.

**Жишээ төсөл:** "Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл", "Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийг сайжруулах төсөл", "Монгол оронд тохиолддог малын цусны шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчний тархалтын судалгаа, оношилгооны оновчтой арга боловсруулах төсөл" гэх мэт.

### ИЕНИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ



Иенийн хөнгөлөлттэй зээл нь уян хатан нөхцлөөр санхүүжилт олгох замаар дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэгт дэмжлэг үзүүлдэг. Мөн хилийн чанад дахь хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлбэр нь хувийн хэвшлийн үйл ажиллагааны санхүүжилтийг дэмждэг хамтын ажиллагаа юм.

**Жишээ төсөл:** "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл", "Цэций салхин станц барих төсөл", "Улаанбаатар хотын Дулааны 4-р цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл", "Инженер, технологийн дээд боловсролын төсөл", Төсөв, нийгэм болон эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл гэх мэт.

### БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ



Эргэн төлөх нөхцөлгүйгээр санхүүжилт олгох замаар сургууль, эмнэлэг зэрэг нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд шаардлагатай байгууламжийг барих, тоног төхөөрөмж нийлүүлэх гэх мэт дэмжлэг үзүүлдэг.

**Жишээ төсөл:** "Улаанбаатар хотын гүүрэн гарц (Нарны гүүр) барих төсөл", "Улаанбаатар хотын ЕБС-ийн барилга барих төсөл", "Монгол-Японы сургалтын эмнэлэг барьж байгуулах төсөл", "Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр" гэх мэт.

### ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА



ЖАЙКА нь хөгжиж буй улс орныг Япон улстай холбох гүүр болж Японы ард түмний олон улсын хамтын ажиллагааны үйл ажиллагааг дэмжин ажилладаг. Энэхүү хамтын ажиллагааг "Иргэдийн оролцоотой хамтын ажиллагаа" гэж нэрлэдэг бөгөөд үүнд сайн дурын гишүүн илгээх, өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа зэрэг хамтын ажиллагаанууд багтдаг.

**Жишээ төсөл:** "Дархан-Уул аймаг дахь амьдралын хэв маягаас гаралтай өвчний урьдчилан сэргийлэлт, эмчилгээг сайжруулах төсөл", "Зөгийн аж ахуйг хөгжүүлэх замаар орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх төсөл" гэх мэт.

ЖАЙКА-ийн сайн дурын мэргэжилтнүүд нь Монгол улсын боловсрол, эрүүл мэнд, аж үйлдвэрийн салбарууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих чиглэлээр тус бүр ажиллаж байна.

### ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ



ЖДҮ эрхлэгчдийн гадаад зах зээлд гарах, бизнесээ тэлж өргөжүүлэхэд чиглэсэн дэмжлэг болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн төслийн бэлтгэл судалгаа зэргээр дамжуулан Японы ЖДҮ эрхлэгчдийн шилдэг технологи, мэдлэг туршлагыг ашиглан хөгжиж буй орнуудын хөгжлийн төрөл бүрийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулдаг.

**Жишээ төсөл:** "Эх ургийн хяналтын мониторинг болон төвлөрсөн хяналтын системийг нэвтрүүлэх замаар Принаталь үеийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах туршилтын төсөл, Рассети идэвхлэх технологи ашигласан арьс ширэн брэнд хөгжүүлэх суурь судалгаа гэх мэт.



## ЖАЙКА-ИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

ЖАЙКА нь дараах 3 тэргүүлэх салбар, 8 хөгжлийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг хамтын ажиллагааны стратеги болгон үйл ажиллагаагаа өргөжүүлж байна.

### 1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРҮҮЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

Макро эдийн засгийг тогтворжуулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд Төрийн санхүүгийн удирдлагын чадавхийг сайжруулахын зэрэгцээ санхүүгийн зах зээлийг бэхжүүлэн, хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгосноор Эрчимтэй зах зээлийн эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлнэ.

### 2 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНТОЙ ЗОХИЦСОН ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ӨСӨЛТ

УБ хотын хэт төвлөрлийг бууруулан, ашигт малтмалын салбараас хараат эдийн засгийн бүтцээс ангижрахын тулд Аж үйлдвэрийг төрөлжүүлж, бүс нутгийн хөгжлийн стратегийг бэхжүүлэхийн зэрэгцээ Эдийн засгийн өсөлтийг хангахуйц өндөр чанартай дэд бүтцийг байгуулан, хүрээлэн буй орчинд ээлтэй, аюулгүй хотыг хөгжүүлэхийг дэмжинэ.

### 3 ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙГ БИЙ БОЛГОХ

Орлогын түвшин, бүс нутгийн ялгааг (боловсрол, эрүүл мэнд, халамж зэрэг) арилгахын тулд Нийгмийн шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандартад хүрэх болон Нийгмийн суурь үйлчилгээний чанарыг сайжруулах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

### 1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРҮҮЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

#### ТӨРИЙН САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ



Бодлогын уялдаа бүхий улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахад чиглэсэн дэмжлэг үзүүлэн, улсын төсвийн орлого, зарлагын хяналттай холбоотой засаглалын чадавхийг бэхжүүлснээр төрийн санхүүгийн удирдлагын тогтвортой тогтолцоог бэхжүүлэхийг зорино.

**Жишээ төсөл:** Улсын төсвийн орлого, зарлагын удирдлага ("Татварын шинэ багц хуулийн хэрэгжилтийг хангах Монгол улсын татварын байгууллагын чадавхийг бэхжүүлэх төсөл", "Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чадавхийг бэхжүүлэх төсөл")-ийн салбарын хамтын ажиллагаа (ТХА-ны төсөл).



Улсын төсвийн орлогын удирдлага нь олон улсын татварын салбарт боловсон хүчин бэлтгэх, улсын байцаагчийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах, татвар хураалтын үйл ажиллагааг сайжруулах зэрэг Монгол улсын татварын албаны чадавхийг бэхжүүлж Монгол улсад тэгш, шударга, зохистой татварын удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мөн улсын төсвийн зарлагын удирдлагын салбарт хөгжлийн бодлого, төсвийн эх үүсвэртэй уялдсан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулж, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

#### ЭРЧИМТЭЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ДЭМЖЛЭГ



Эдийн засгийн үйл ажиллагааны суурь болох санхүүгийн зах зээлийг бэхжүүлж, бизнесийн орчинг сайжруулах зэргээр хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авч эрчимтэй зах зээлийн эдийн засгийг дэмжихийг зорино.

**Жишээ төсөл:** "Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх", "Шударга өрсөлдөөний орчинг бүрдүүлэх" хамтын ажиллагаа (ТХА-ны төсөл).

Санхүүжилтийн аргад банк голлосон шууд бус санхүү давамгайлж буй нөхцөлд хөрөнгийн зах зээлийн хяналт зохицуулалтыг бэхжүүлснээр зах зээл дэх итгэл дээшилж, шинээр олон нийтэд хувьцаа гаргах зэрэг эрчимтэй үйл ажиллагаанд чиглэсэн хөрөнгийн биржид бүртгүүлэх орчинг бэхжүүлэх, корпорацийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Мөн зах зээлийн шударга өрсөлдөөний орчинг бүрдүүлэхэд чиглэн өрсөлдөөний хуулийн шинэчлэл болон өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагааны хяналт шалгалтын чадавхийг бэхжүүлэх тал дээр дэмжлэг үзүүлж байна.



## 2



## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНТОЙ ЗОХИЦСОН ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ

### АЖ ҮЙЛДВЭРИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙГ БЭХЖҮҮЛЭХ



Аж үйлдвэрийг төрөлжүүлэн, бүс нутгийн хөгжлийн стратегийг бэхжүүлснээр дунд болон урт хугацаанд Монголын баялаг болсон хүрээлэн буй орчинтой зохицсон, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангахыг зорино.

**Жишээ төсөл:** “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл” (Иенийн хөнгөлөлттэй зээл)

Аж үйлдвэрийг төрөлжүүлэх, байгаль орчныг хамгаалах зорилгоор жижиг дунд үйлдвэрүүдэд урт хугацааны зээл олгохын зэрэгцээ, дамжуулан зээлдүүлэгч санхүүгийн байгууллага болон жижиг дунд үйлдвэрүүдийн чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлж байна. Өнөөг хүртэл төслийн 1, 2-р шатанд нийт 700 компанид 750 сая иений зээл олгосон.

### ӨСӨЛТИЙГ ХАНГАХУЙЦ ӨНДӨР ЧАНАРТАЙ ДЭД БҮТЦИЙГ БАЙГУУЛАХ



“Өндөр чанартай дэд бүтэц” гэсэн зарчмаар зам тээвэр, эрчим хүчний дэд бүтцийг байгуулах, ашиглалт, засвар үйлчилгээг оновчтой хийхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулахыг зорино.

**Жишээ төсөл:** “Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төсөл” (Иенийн хөнгөлөлттэй зээл, ТХА-ны төсөл)

Агаарын тээврийн эрэлт өссөнөөр нийслэл хотын нисэх буудлын аюулгүй байдал, итгэлийг сайжруулахын тулд шинэ нисэх буудлыг хөнгөлөлттэй зээлээр барьж, дэмжлэг үзүүлж байна. Мөн шинэ нисэх буудлыг ашиглалтанд саадгүй оруулах, засвар үйлчилгээг оновчтой хийхэд чиглэсэн техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

### ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, АЮУЛГҮЙ ХОТЫГ БИЙ БОЛГОХ



Агаарын бохирдол гэх мэт Байгаль орчны асуудал шийдвэрлэлтийг үргэлжлүүлэн дэмжиж, хот байгуулалтын салбарын хууль эрхзүйн тогтолцоонд үндэслэсэн гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлэх болон гамшгаас хамгаалах үйл ажиллагааг дэмжин ажиллах замаар хүрээлэн буй орчинд ээлтэй, аюулгүй хотыг байгуулахад хувь нэмэр оруулахыг зорино.

**Жишээ төсөл:** “УБ хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл” (ТХА-ны төсөл)

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр өнөөг хүртэл 2 үе шаттай хэрэгжсэн төслүүдийн хүрээнд агаар орчны хяналтын мэдээллийн системийн удирдлага, нарийвчлалыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. 3-р шатны төслөөр УБ хотын агаарын бохирдлыг бууруулах ажлыг илүү бодит үр дүнд хүргэхэд чиглэн ажиллаж байна.

## 3



## ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙГ БИЙ БОЛГОХ

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТЫГ НИЙГМИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭХ



Эрүүл мэндийн боловсон хүчнийг бэхжүүлэн, эдийн засгийн өсөлттэй уялдсан чанартай тусламж үйлчилгээг үзүүлэх, бүс нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний ялгааг багасган, дундаж давхаргын өсөлтийг дагалдах өвчний бүтцийн өөрчлөлтийг хамарсан эрүүл мэндийн системийг бий болгох замаар Монгол улсын эрүүл мэндийн салбарын түвшинг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна.

**Жишээ төсөл:** “Монгол-Японы сургалтын эмнэлэг барих төсөл”, “Монгол-Японы сургалтын эмнэлгийн хүний нөөцийг чадавхижуулах, менежментийг төгөлдөршүүлэх төсөл” (Буцалтгүй тусламж, ТХА-ны төсөл)

Эмнэлзүйн практик дадлага туршлага багатай эмнэлгийн мэргэжилтнүүдийн боловсон хүчний чанарыг сайжруулах нэн шаардлагатай байгаа үед буцалтгүй тусламжийн хүрээнд АШУУИС-ийн харъяа их сургуулийн эмнэлэг барьж байгуулах, эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах техникийн хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлж байна.

### НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ



Эрүүл, тогтвортой нийгмийг бий болгоход чиглэсэн нийгмийн суурь үйлчилгээг (суурь боловсрол, нийгмийн хамгаалал гэх мэт) иргэдэд адил тэгш хүргэж, үйлчилгээний чанарыг сайжруулахыг зорино.

**Жишээ төсөл:** “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” (2-р үе шат. ТХА-ны төсөл, Сайн дурын гишүүн)

Тэгш, хүртээмжтэй боловсролыг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн тогтолцоог сайжруулах, сургууль тойрсон бүс нутгийн тогтолцоог бий болгох, багш бэлтгэх сургалтын чиглэлээр хамтран ажиллах техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мөн цэцэрлэг, бага сургууль зэрэг боловсролын байгууллагад Япон сайн дурын гишүүдийг олноор илгээн ажиллуулдаг.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ




Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэдийг эрт оношлогоонд хамруулж, ажил эрхлэлт, нийгмийн оролцоог хангах бүх дэмжлэгийг үзүүлнэ. Ингэснээр тэгш боловсрол шаардлагатай хүүхдийн хэрэгцээнд нийцсэн оновчтой хөгжлийн дэмжлэг, боловсрол эзэмших боломжтой болох бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо сайжрах юм.

**Жишээ төсөл:** “Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх” төсөл (ТХА-ны төсөл)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг сайжруулах үүднээс ААН болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг холбох “Ажлын байранд дадлагжуулагч”-ийг сургах, ААН-ийн ойлголт, хандлагыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.





## ЭРХЭМ ЗОРИЛГО

ЖАЙКА нь Хөгжлийн Хамтын Ажиллагааны үзэл баримтлалын хүрээнд хүний аюулгүй байдал, чанартай хөгжлийг ханган ажиллана.

## АЛСЫН ХАРАА

LEADING THE WORLD WITH TRUST.

Даян дэлхийг итгэлээр холбоно. ЖАЙКА нь хамтрагчтайгаа мөр зэрэгцэн бүх дэлхийн хүмүүс гэрэлт ирээдүйдээ итгэн, арвин боломжийг эрэлхийлсэн эрх чөлөөт, амар амгалан, баялаг дэлхийг бий болгохыг эрмэлзэж, даян дэлхийг итгэлээр холбоно.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- 1. Үүрэг хариуцлага**  
Бахархал, хүсэл тэмүүлэлтэйгээр үүрэг хариуцлагаа биелүүлнэ.
- 2. Гэнба**  
Гэнба (ажлын талбар) дээр гар бие оролцон, бусадтай хамтран ажиллана.
- 3. Стратеги**  
Урт хугацаанд өргөн цар хүрээтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.
- 4. Хамтын бүтээл**  
Салбар бүрийн мэдлэг, нөөц баялагийг нэгтгэнэ.
- 5. Инноваци**  
Урьд өмнө байгаагүй нөлөөллийг бий болгохын тулд шинэлэгээр сэтгэнэ.

## ЖАЙКА-ИЙН МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Хаяг: Бодь цамхаг 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар

Утас: +976-11-312393/311329

Факс +976-11-310845

И-Мэйл: [mg\\_oso\\_rep@jica.go.jp](mailto:mg_oso_rep@jica.go.jp)

Вэб хуудас: <https://www.jica.go.jp/mongolia/mon/index.html>

Фэйсбүүк: [www.facebook.com/JICA-Mongolia](https://www.facebook.com/JICA-Mongolia)

YouTube: JICA Mongolia - YouTube

